

**БОЛОВСРОЛЫН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ГЭР БҮЛ,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2025 оны 02 дугаар
сарын 21-ны өдөр

Дугаар А/85 / А/55 / А/49...

Улаанбаатар
хот


Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол
эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий
дэмжих төвийн дүрэм батлах тухай


Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.25 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 39¹ дүгээр зүйлийн 39¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан дүрмийн хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар (З.Бауыржан), Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт, дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий төвийн удирдлагад тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсролын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Н.Нарангэрэл), Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр), Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Ц.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.





ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ДЭМЖИХ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн (цаашид “хүн” гэх)-д боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээ (цаашид “дэмжих үйлчилгээ” гэх) үзүүлэх дэмжих төв (цаашид “дэмжих төв” гэх)- ийн үйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулна.

1.2. Энэхүү дүрмийн 1.1-д заасан дэмжих төв нь хүнд дэмжих үйлчилгээ үзүүлэх нэгж байна.

1.3. Энэхүү дүрмийн 1.2-т заасан нэгжийг доор дурдсан байгууллагыг түшиглэн ажиллуулна:

- 1.3.1. хүүхдийн цэцэрлэг;
- 1.3.2. ерөнхий боловсролын сургууль;
- 1.3.3. насан туршийн суралцахуйн төв;
- 1.3.4. сэргээн засах төв;
- 1.3.5. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв;
- 1.3.6. хүүхдийн сэргээн засах төв
- 1.3.7. сэргээн засах эмнэлэг
- 1.3.8. сувилал;
- 1.3.9. хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв
- 1.3.10. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах эрх бүхий байгууллага

1.4. Дэмжих төв нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.3, 4.1.8-д заасан хэрэглэгдэхүүн, хэрэгсэлтэй байх ба холбогдох хууль тогтоомж, стандартад заасан шаардлага хангасан орчинтой байна.

1.5. Дэмжих төв нь байнгын асаргаа шаардлагатай нь тогтоогдсон, танхимын сургалтад тогтмол хамрагдахад саад бэрхшээлтэй¹ хүнд дэмжих үйлчилгээг үзүүлнэ.

1.6. Энэхүү дүрмийн 1.3-т заасан байгууллага дэмжих үйлчилгээг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу төрийн бус өмчийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

1.7. Дэмжих үйлчилгээ үзүүлж байгаа ажилтан үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, эрх бүхий этгээдийн баталсан шийдвэрийг мөрдөн ажиллана.

¹ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Олон улсын стандарт ангилал:
биеийн үйлдэл, эрхтэн тогтолцооны алдагдалтай холбоотой саад бэрхшээлтэй (Body functions and structure related barriers)
үйл ажиллагаа болон оролцоотой холбоотой саад бэрхшээлтэй (Activities and participation related barriers)
орчин нөхцөлтэй холбоотой саад бэрхшээлтэй (Context-related barriers)

Хоёр. Дэмжих төвийн үйл ажиллагаа, зохион байгуулалт

2.1. Дэмжих төв нь доор дурдсан дэмжих үйлчилгээг үзүүлнэ:

2.2. Боловсролын үйлчилгээ:

2.2.1. боловсролын үйлчилгээг Боловсролын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлд заасан хэлбэрээр, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй зөвшилцсөний үндсэн дээр зохион байгуулна.

2.2.2. боловсролын үйлчилгээг Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 16.2-д заасан шаардлага хангасан багш үзүүлнэ.

2.2.3. боловсролын үйлчилгээг албан боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тохируулга хийж, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.2.4. боловсролын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг Боловсролын ерөнхий хуулийн 11.6, 38.1.1, 38.1.2, 38.1.4, 38.1.5, 38.5.4-т зааснаар олгоно.

2.3. Эрүүл мэндийн үйлчилгээ:

2.3.1. эрүүл мэндийн үйлчилгээг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар, Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх журмын дагуу зохион байгуулна.

2.3.2. эрүүл мэндийн үйлчилгээг Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.7-д заасан зөвшөөрөлтэй, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 13.4-т заасан мэргэжилтэн үзүүлнэ.

2.3.3. хүүхдийн чадвар алдалтыг батлагдсан журам, эмнэлзүйн зааврын дагуу үнэлж, оношлон сэргээн засах үйлчилгээ /сэргээн засах, нийгмийн эрүүл мэндийн, сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ/-г ганцаарчилсан төлөвлөгөөгөөр үзүүлнэ.

2.3.4. эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авдаг төр, хувийн хэвшлийн сэргээн засах эмнэлэг, сувилал, уламжлалтын эмнэлэгтэй гэрээ байгуулах замаар олгоно.

2.4. Нийгмийн хамгааллын үйлчилгээ:

2.4.1. нийгмийн хамгааллын талаас Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан үйлчилгээ 25.1.1, 25.1.2, 25.1.3-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдох үйлчилгээг үзүүлнэ.

2.4.2. энэ дүрмийн 2.4.1-д заасан үйлчилгээг нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн, мэргэжлийн диплом, гэрчилгээтэй ажилтан үзүүлнэ.

2.4.3. нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8.4-д зааснаар шийдвэрлэнэ.

2.5. Дэмжих төв нь энэхүү дүрмийн 1.5-д заасан хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн төлөөллөөс бүрдсэн, дэмжих төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус Зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-тэй байна.

2.6. Энэхүү дүрмийн 2.5-д заасан Зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.6.1. төвийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

2.6.2. төвийн санхүүжилтийн зарцуулалт, тайлагналтыг хянах, баталгаажуулах;

2.6.3. төвийн хүний нөөцийн хангалт, ур чадварын талаар хэлэлцэж, холбогдох зөвлөмж гаргах;

2.6.4. төвөөр үйлчлүүлж буй хүний ахиц өөрчлөлтийг үнэлэх, дүгнэх ажлыг улирал бүр эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон тухайн орон нутгийн Салбар комисстой хамтран мэргэжлийн байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулах;

2.6.5. Дэмжих төвийн үйлчилгээнд хамрагдсан хүний талаарх тайлан, мэдээг батлагдсан маягтын дагуу улирал бүр тухайн орон нутгийн Салбар комисст албан бичгээр хүргүүлэх.

2.7. Дэмжих төв нь энэхүү дүрмийн 1.5-д заасан хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтийг үндэслэн дэмжих үйлчилгээнд хамруулж, дараах арга хэмжээг авна:

2.7.1. дэмжих үйлчилгээнд хамрагдсан хүний мэдээллийг холбогдох мэдээллийн системд бүртгэх /*esis, ehalamj, cwd.mlsp.gov.mn*/;

2.7.2. хүүхдийн хөгжлийн дэвтрийг нээж, хөтлөх.

2.8. Дэмжих үйлчилгээ үзүүлж байгаа ажилтан нь:

2.8.1. эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан, халдварт болон сэтгэцийн өвчингүйг тодорхойлсон эмнэлгийн магадалгаатай байна.

2.8.2. дэмжих үйлчилгээнд хамрагдсан хүний ирц, бүртгэл, үйлчилгээний нэр төрөл, үргэлжлэх хугацаа, ганцаарчилсан төлөвлөгөөний хэрэгжилт, гарч буй ахиц, өөрчлөлт, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн сэтгэл ханамжийг тэмдэглэн баримтжуулж, бүртгэл, судалгаа хөтөлнө.

2.9. дэмжих үйлчилгээнд хамрагдсан хүн өөрөө болон эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гарган тухайн дэмжих төвөөс шилжих, татгалзах тохиолдолд холбогдох баримт бичигт хасалт, нэмэлтийг бүрэн бичиж тэмдэглэн дараагийн байгууллагад холбон зуучилж, хүлээлгэж өгнө.

Гурав. Бусад

3.1. Дэмжих төв нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээ, мэдээллийг холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт заасны дагуу цаг хугацаанд нь шуурхай, үнэн, зөв, ил тод, тогтмол тайлагнаж, мэдээлнэ.

3.2. Дэмжих төв нь тайлан, мэдээг цаасан болон цахим хэлбэрээр архивлан хадгална.